



МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО



“ХӨГЖЛӨӨС ХЭНИЙГ Ч ОРХИГДУУЛАХГҮЙ”
ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗАРЧИМ:

ЖЕНДЕРИЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТИЙН ОЛОН ШАТЛАЛТ ЗАДАРГАА



ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО

“ХӨГЖЛӨӨС ХЭНИЙГ Ч ОРХИГДУУЛАХГҮЙ”
ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗАРЧИМ:

ЖЕНДЕРИЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТИЙН ОЛОН ШАТЛАЛТ ЗАДАРГАА

Улаанбаатар
хот 2021 он

Танилцуулгыг бичсэн:

О.Норовсамбуу ҮСХ-ны ҮТШСГ-ын статистикч
Б.Гэрэлцэцэг ҮСХ-ны ҮТШСГ-ын статистикч

Танилцуулгыг хянан тохиосон:

Ч.Баянчимэг ҮСХ-ны дэд дарга
А.Дэмбэрэл ҮСХ-ны ҮТШСГ-ын дарга
Н.Өлзийханд ҮСХ-ны ҮТШСГ-ын ахлах статистикч

МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО

Монгол Улс, Улаанбаатар хот
Сүхбаатар дүүрэг, Бага тойруу-44
Засгийн газрын III байр
Утас: (976-11)-326414, 1900-1212
Факс: (976-11)-324518
Цахим хуудас: <http://nso.mn>, www.1212.mn
И-мэйл: information@nso.mn

Агуулга

Товч агуулга.....	4
“Хөгжлөөс хэнийг ч орхигдуулахгүй” тогтвортой хөгжлийн зарчим.....	5
“Хөгжлөөс хэнийг ч орхигдуулахгүй” зарчмын дагуух олон шатлалт задаргааны аргачлал	7
1. Тооцоолол хийх өгөгдлийн сан	7
2. Задаргаанд ашиглагдах хувьсагчид.....	8
3. Олон шатлалт задаргааны үе шат.....	8
ТХЗ-ын зарим үзүүлэлтүүдийн олон шатлалт задаргаа.....	9
1. Эрт гэрлэлт – ТХЗ 5.3.1.....	9
2. Ундны усны хангамж – ТХЗ 6.1.1	12
3. Ариун цэврийн байгууламжгүй – ТХЗ 6.2.1.....	15
4. Хоол болгох цэвэр түлшгүй – ТХЗ 7.1.2.....	18
5. Орон сууцны тохиромжгүй нөхцөл - ТХЗ 11.1.1	20
Нэгдсэн үр дүн	23
Ашигласан материал.....	25

Зургийн жагсаалт

Зураг 1. Задаргаанд ашигласан хувьсагчид.....	8
Зураг 2. Насанд хүрээгүй байхдаа гэрлэсэн 15-49 насны эмэгтэйчүүд, хувиар.....	9
Зураг 3. Насанд хүрээгүй байхдаа гэрлэсэн 15-49 насны эмэгтэйчүүд, бүс-байршил, аж байдлын түвшин-байршил, хувиар	10
Зураг 4. Насанд хүрээгүй байхдаа гэрлэсэн 15-49 насны эмэгтэйчүүд, аж байдлын түвшин, байршил, бүсээр, хувиар.....	10
Зураг 5. Дэлхийн үндны усны хангамж, хувиар, 2015 он	12
Зураг 6. Ундны усны суурь үйлчилгээгээр хангагдаагүй 15-49 насны эмэгтэйчүүд, хувиар.....	13
Зураг 7. Ундны усны суурь хэрэглээгээр хангагдаагүй 15-49 насны эмэгтэйчүүд, аж байдлын түвшнээр, байршлаар, хувиар.....	13
Зураг 8. Ундны усны суурь хэрэглээгээр хангагдаагүй 15-49 насны эмэгтэйчүүд, аж байдлын түвшин, бүс, байршлаар, хувиар.....	14
Зураг 9. Ариун цэврийн байгууламжийн хангамж, дэлхийн түвшинд, 2015 он, хувиар	15
Зураг 10. Ариун цэврийн байгууламжийн суурь үйлчилгээгээр хангагдаагүй 15-49 насны эмэгтэйчүүд, хувиар	16
Зураг 11. Ариун цэврийн байгууламжийн суурь үйлчилгээгээр хангагдаагүй 15-49 насны эмэгтэйчүүд, аж байдлын түвшнээр, байршлаар, хувиар.....	17
Зураг 12. Ариун цэврийн байгууламжийн суурь үйлчилгээгээр хангагдаагүй 15-49 насны эмэгтэйчүүд, бүсээр, байршлаар, аж байдлын түвшнээр, хувиар	17
Зураг 13. Хоол болгох цэвэр түлш ашигладаггүй 15-49 насны эмэгтэйчүүд, хувиар	18
Зураг 14. Хоол болгох цэвэр түлш ашигладаггүй 15-49 насны эмэгтэйчүүд, аж байдлын түвшнээр, байршлаар, хувиар.....	19
Зураг 15. Хоол болгох цэвэр түлш ашигладаггүй 15-49 насны эмэгтэйчүүд, бүсээр, байршлаар, аж байдлын түвшнээр, хувиар	19
Зураг 16. Хангалттай зай талбайд амьдардаггүй 15-49 насны эмэгтэйчүүд, хувиар	20
Зураг 17. Хангалттай зай талбайд амьдардаггүй 15-49 насны эмэгтэйчүүд, аж байдлын түвшнээр, байршлаар, хувиар.....	21
Зураг 18. Амьдрах хангалттай зай талбайгүй 15-49 насны эмэгтэйчүүд, бүсээр, байршлаар, аж байдлын түвшнээр, хувиар.....	22
Зураг 19. Ялгаатай бүлгүүдэд амьдарч буй 15-49 насны эмэгтэйчүүдийн тэгш бус байдлын үзүүлэлтүүд, хувиар.....	23

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1. Үндсэн боломжийг илэрхийлэх индикатор, ТХЗ-ын хамаарал.....	6
Хүснэгт 2. Ундны усны үйлчилгээний түвшин	12
Хүснэгт 4. Ариун цэврийн байгууламжийн үйлчилгээний түвшин	15

Товчилсон үгийн жагсаалт

НҮТС	Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа
ТХЗ	Тогтвортой хөгжлийн зорилт
ҮСХ	Үндэсний статистикийн хороо

Товч агуулга

Хөгжлийн үйл явцаас хэн ч ард үлдэж хоцрохгүй байх ёстой.

Хэнийг ч ард үлдээн хоцроохгүйн тулд ТХЗ-2030 хөтөлбөрийг дэлхийн улс орнууд тунхаглан баталсан билээ. Гэсэн ч охид, эмэгтэйчүүд хөгжил дэвшлээс олж авах боломж хязгаарлагдмал, жендерийн уламжлалт ялгаварлан гадуурхалт оршоор байгаа юм.

Дэлхийн хүн амын тал хувийг эмэгтэйчүүд эзэлдэг. Энэ ч утгаараа дэлхий дээрх нийт нөөц бололцоо, хүчин чадлын тал хэсэг нь эмэгтэйчүүдээс хамаардаг гэсэн үг юм. Хэрвээ тэдний амьдралын нөхцөл дээшилбэл энэ нь нийт нийгэм даяар тархана.

Эмэгтэйчүүд зохистой хөдөлмөр эрхэлж, өөрийн гэсэн тогтмол орлоготой болсноор зөвхөн ядуурал (ТХЗ-1) буураад зогсохгүй тэднээс хамаардаг охид, хөвгүүд илүү дээр боловсрол, эрүүл мэнд, шим тэжээлээр (ТХЗ-2, 3, 4) хангагдах нөхцөл бүрдэх юм.

Охид, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг арилгах нь бүх насны хүмүүсийн сайн сайхан, эрүүл саруул амьдралтай (ТХЗ-3) холбогддог.

НҮТС-2018 судалгаанаас тооцсон олон шатлалт шинжилгээгээр, гачигдлын хамгийн хүнд хэлбэрт Хангайн бүсийн - аймгийн төвд амьдардаг - аж байдлын доогуур түвшний - 15-49 насны эмэгтэйчүүд амьдарч байна.

Эдгээр эмэгтэйчүүдийн 57.8 хувь нь ундны усны суурь хэрэглээгээр хангагдаагүй, 34.7 хувь нь ариун цэврийн суурь үйлчилгээг ашиглаж чадахгүй, 100 хувь буюу бүгд хоол болгох цэвэр түлш болон амьдрахад тохиромжтой зай талбайтай орон гэргүй, 17.6 хувь нь насанд хүрээгүй байхдаа гэрлэсэн байна.

Тэгш бус байдлын үзэл баримтлал

Тэгш бус байдлын ойлголт нь ихэвчлэн сайн сайхан байдлыг орлогоор төлөөлүүлэн авч үздэг, “аж байдалд чиглэсэн” уламжлалт үзэл баримтлалыг голчилсон байдаг.

Харин боломжид-чиглэсэн үзэл баримтлалаар, “аж байдал”-д тухайн хүний төрсөн орчин нөхцөл ихээхэн нөлөөлдөг учраас аж байдлын түвшин гэх мэт бусад хүчин зүйлээс хамаарахгүйгээр хүн бүрд “боломж”-ийг олж авах тэгш эрх өгөгдсөн байх ёстой үздэг.

Тиймээс тэгш бус байдлын үзэл баримтлалыг үндсэн 2 чиглэлд хялбарчлан ангилбал:

Нэгдүгээрт, “аж байдлын” тэгш бус байдал. Ихэвчлэн хүний сайн сайхан байдлын материаллаг хэмжүүрийг хамруулна, жишээлбэл, орлого/ баялгийн хэмжээ, боловсролын түвшин, эрүүл мэндийн байдал гэх мэт.

Хоёрдугаарт, боломжийн тэгш бус байдал. Хүн бүрд сонголт хийх тэгш боломж байх, жишээлбэл, ажил эрхлэх тэгш боломж, боловсрол эзэмших тэгш боломж, сайжруулсан ариун цэврийн байгууламж ашиглах боломж гэх мэт.

“Хөгжлөөс хэнийг ч орхигдуулахгүй” тогтвортой хөгжлийн зарчим

Даян дэлхийн хүн ардын энх тайван амьдрал, хөгжил цэцэглэлт, байгаль орчны тогтвортой байдлын төлөө дэлхийн бүх улс үндэстэн нэгдэн “Тогтвортой хөгжил - 2030 хөтөлбөр”-ийг 2015 онд тунхаглан баталсан.

Дэлхий дахинаа ядуурал, гачигдлыг үгүй хийхийн тулд хүн ардын боловсрол, эрүүл мэндийг сайжруулж, тэгш бус байдлыг арилгаж, эдийн засгийн өсөлтийг дэмжихийн зэрэгцээ уур амьсгалын өөрчлөлтийг даван туулж, далай тэнгис, эх дэлхий, байгаль орчноо авран хамгаалах учиртайг улс үндэстнүүд нэгэн сэтгэлээр хүлээн зөвшөөрч, хүчээ нэгтгэн хамтран хэрэгжүүлэх 17 зорилгыг уг хөтөлбөрийн хүрээнд дэвшүүлсэн юм. (ҮСХ, 2020)

Тогтвортой хөгжил нь хүн бүрд хамаатай асуудал тул хэнийг ч ардаа үлдээн, орхигдуулахгүй байх учиртай.

“Хөгжлөөс хэнийг ч орхигдуулахгүй” зарчим нь тогтвортой хөгжлийг цогцлоох үндсэн суурь үзэл баримтлал бөгөөд “хүний эрх”-д суурилдаг. Үндсэндээ ТХЗ-ын 2030 Хөтөлбөр нь “хүмүүсийг хөгжлөөс хоцроож” буй циклийг эвдэх, тэгш бус байдлыг үгүй хийх зорилготой.

Эдийн засгийн өсөлтийн үр шим нийгэм дэх хамгийн чинээлэг хэсэгт ихээр хувилагдан, ядуу болон чинээлэг бүлгүүдийн амьдралын түвшний ялгаа нэмэгдсээр байна. Дэлхийн тэгш бус байдлын 2018 оны тайланд дурдсанаар, дэлхийн хүн амын орлогын тэгш бус байдал 1980 оноос хойш улам гүнзгийрч байна.

Тэгш бус байдал улам гүнзгийрснээр “ард үлдэж, орхигдож буй хүмүүс” нь хөгжил, инновац, эдийн засгийн өсөлт, глобалчлалын үйл явцад оролцож, үр шимийг нь хүртэж чадахгүй байгаа юм.

Энэхүү улам бүр гүнзгийрч байгаа тэгш бус байдал нь зөвхөн орлогын тэгш бус байдлаар хэмжигддэггүй. Тэгш бус байдал нь “боломж”-ийг олж авахад мөн хамаардаг.

Бүх хүмүүст үндсэн үйлчилгээг эдлэх “боломж” олгох буюу уг “боломж”-ийг олж авах тэгш байдлыг хангавал “орхигдохгүй” бөгөөд хүмүүст өөрсдийн нийгэм-эдийн засгийн байдлыг дээшлүүлэх боломж ижил өгөгдсөн байна гэсэн үг юм.

Боломжийн тэгш бус байдлыг илрүүлэх индикаторуудыг үндсэн болон туслах гэж ангилж болно.¹ ТХЗ-ын 2030 хөтөлбөрт тусгагдсан, үндсэн боломжийг илэрхийлэх 12 индикатор байна.

¹ Predrag Savic, Yichun Wang, Leaving no one behind: A methodology to identify those furthest behind in accessing opportunities in Asia and the Pacific, working paper, ESCAP, UN

Хүснэгт 1. Үндсэн боломжийг илэрхийлэх индикатор, ТХЗ-ын хамаарал

Боломж/ Индикатор		Холбогдох ТХЗ	
Үндсэн боломж	1	Бүрэн дунд боловсрол	4.1.1 (i) Унших болон (ii) тоо бодох наад захын чадварыг эзэмшсэн (a) 2/3-р анги, (b) бага анги төгссөн, (c) дунд анги төгссөн хүүхэд, залуучуудын эзлэх хувь, хүйсээр
	2	Дээд боловсрол	4.3.1. Сүүлийн 12 сарын хугацаанд албан болон албан бус боловсрол, сургалтад хамрагдсан залуучуудын тухайн насны хүн амд эзлэх хувь, хүйсээр
	3	Өсөлтийн хоцрогдол	2.2.1 Өсөлтийн хоцролттой 5 хүртэлх насны хүүхдийн тухайн насны хүүхдэд эзлэх хувь (биеийн өндөр, насны харьцаа нь ДЭМБ-аас боловсруулсан хүүхдийн өсөлтийн стандарт харьцааны голчоос стандарт хазайлт нь "- 2"-оос бага)
	4	Илүүдэл жин	2.2.2 Хоол тэжээлийн дутагдалтай болон илүүдэл жинтэй 5 хүртэлх насны хүүхдийн тухайн насны хүүхдэд эзлэх хувь, төрлөөр (биеийн жин, өндрийн харьцаа нь ДЭМБ-аас боловсруулсан хүүхдийн өсөлтийн стандарт харьцааны голчоос стандарт хазайлт нь "+2"-оос их, "-2"-оос бага)
	5	Туранхай	
	6	Жирэмслэхээс сэргийлэх орчин үеийн аргын хэрэглээ	3.7.1 Гэр бүл төлөвлөлтийн хэрэгцээгээ жирэмслэхээс сэргийлэх орчин үеийн аргаар хангасан нөхөн үржихүйн (15-49) насны эмэгтэйчүүдийн тухайн насны эмэгтэйчүүдэд эзлэх хувь
	7	Хүүхэд төрүүлэхдээ мэргэжлийн хүний туслалцаа авах	3.1.2 Эмнэлгийн мэргэжилтний эх барьсан төрөлтийн эзлэх хувь
	8	Ундны усны цэвэр эх үүсвэр	6.1.1 Баталгаат ундны усны эх үүсвэрээр хангагдсан хүн амын нийт хүн амд эзлэх хувь
	9	Ариун цэврийн байгууламж	6.2.1 а) Эрүүл ахуйн шаардлага хангасан ариун цэврийн байгууламжаар хангагдсан хүн амын нийт хүн амд эзлэх хувь, үүнд: (b) гар угаах саван, ус, угаалтуурыг хамруулна.
	10	Эрчим хүч	7.1.1 Цахилгаан эрчим хүчээр хангагдсан хүн амын нийт хүн амд эзлэх хувь
	11	Цэвэр түлш	7.1.2 Цэвэр түлш, технологийг голчлон хэрэглэдэг хүн амын эзлэх хувь
	12	Банкны данс	8.10.2 Банканд болон бусад банк санхүүгийн байгууллагад өөрийн гэсэн данстай эсвэл гар утсаар банк, санхүүгийн үйлчилгээ авсан насанд хүрэгчдийн (15 ба түүнээс дээш) тухайн насны хүн амд эзлэх хувь

“Хөгжлөөс хэнийг ч орхигдуулахгүй” зарчмын дагуух олон шатлалт задаргааны аргачлал

“Хөгжлөөс хэнийг ч орхигдуулахгүй” үзэл баримтлал нь улс орон доторх тэгш бус байдлыг илрүүлэн гаргаж ирэх, үндсэн шалтгааныг нь олж тогтооход чиглэнэ. Уг зорилгыг хэрэгжүүлэхийн тулд хэн хөгжлөөс орхигдож буйг олж илрүүлэх нь зайлшгүй юм.

Охид, эмэгтэйчүүд хөгжлөөс хоцорч үлдэх эрсдэлд өртөмтгий байдаг. Энэхүү “хүйс”-т суурилсан ялгаатай байдлаас гадна нийгэм эдийн засгийн шинж чанар, жишээлбэл, хөдөө оршин суух, ядуу өрхөд амьдрах гэх мэтээс шалтгаалсан давхардсан эрсдэлд өртөх хандлага ажиглагддаг.

Хэд хэдэн төрлийн, давхардсан эрсдэлд амьдарч буй эмэгтэйчүүд гачигдлын хамгийн хүнд нөхцөлд байх магадлал хамгийн өндөр юм. (UN Women, 2018)

Хэн хамгийн хойно орхигдож, давхардсан гачигдлын түвшинд амьдарч байгааг олж илрүүлэхийн тулд өмнө дурдсан “үндсэн боломж”-оор хангагдаж чадахгүй байгаа бүлгүүдийг хүйс болон бусад үзүүлэлтүүдээр нэгэн зэрэг задална.

ХАҮ шинжилгээний үе шат:

1. Тооцоолол хийх өгөгдлийн санг тодорхойлох: Өгөгдлийн сан нь хангалттай түүврийн хэмжээтэй байх шаардлагатай.
2. Олон шатлалт задаргаанд ашиглах хувьсагчдаа тодорхойлох:
3. Үндсэн боломжуудыг илэрхийлэх ТХЗ-ын үзүүлэлтүүдийг тооцоолох
4. Үр дүнг нэгтгэх

1. Тооцоолол хийх өгөгдлийн сан

Энэ төрлийн тооцооллыг боловсруулахын тулд судалгааны анхан шатны мэдээлэл шаардлагатай. Мөн хамгийн гачигдалтай бүлгүүдийг тодорхойлохын тулд олон шатлалт задаргаа ашиглагдах учир судалгаа, тооллогын мэдээлэл нь хангалттай хэмжээ бүхий байх шаардлагатай юм.

Тооцооллын олон улсад харьцуулагдах байдлыг хангахын тулд стандартчилагдсан судалгаануудын мэдээллийн баазыг ашиглахыг зөвлөдөг, жишээлбэл, “Ажиллах хүчний судалгаа” (LFS), “Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа” (MICS) гэх мэт.

Энэхүү шинжилгээ, судалгааны ажлыг “Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа-2018” (MICS)-г ашиглан гүйцэтгэв. Өмнө дурдсан “үндсэн боломж”-ийг илэрхийлэх индикаторуудын дагуу НҮТС-2018 судалгааны үр дүнгээс эмэгтэйчүүдийн хувьд тооцогдох боломжтой 5 үзүүлэлтийг олон шатлалт задаргаагаар тооцсон. Эрэгтэйчүүдийн хувьд тооцох өгөгдлийн сан нь хангалттай түүврийн хэмжээ бүхий биш байна.

Олон шатлалт задаргааг “Stata 13” программ ашиглан гүйцэтгэв. Дүнд эзлэх хувийн жинг судалгаанд хамрагдсан 15-49 насны эмэгтэйчүүдийн хувьд жигнэсэн.

	Үр дүнгийн үзүүлэлт	Тооцоололд ашиглагдах судалгааны өгөгдөл
1	Эрт гэрлэлт - ТХЗ 5.3.1	НҮТС /MICS: wm/
2	Ундны усны хангамж - ТХЗ 6.1.1	НҮТС /MICS: hh, wm/
3	Ариун цэврийн байгууламж - ТХЗ 6.2.1	НҮТС /MICS: hh, wm/
4	Хоол болгох цэвэр түлш - ТХЗ 7.1.2	НҮТС /MICS: hh, wm/
5	Орон сууцны тохиромжгүй нөхцөл - ТХЗ 11.1.1	НҮТС /MICS: hh, wm/

2. Задаргаанд ашиглагдах хувьсагчид

Энэхүү судалгаагаар “НҮТС-2018”-ын үр дүнг ашиглан хамгийн гачигдалтай, эмзэг байдалд амьдарч буй эмэгтэйчүүдийг олж илрүүлэхийг зорьсон болно. Аж байдал, байршил, бүс, угсаатан, шашин шүтлэгийн байдлаар олон шатлалт задаргааг гүйцэтгэсэн.

Зураг 1. Задаргаанд ашигласан хувьсагчид



Улсын түвшний төлөөлөх чадвартай өрхийн судалгаанууд нь өгөгдлийг хүйсээр задлахад хангалттай төлөөлөх чадвартай байдаг хэдий ч хэд хэдэн хувьсагчдаар, жишээлбэл аж байдал, байршил гэх мэт, олон шатлалт задаргааг гүйцэтгэхэд түүврийн хэмжээг сайтар нягтлах шаардлагатай.

Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаанд өрхийн орон сууцны материал, цахилгаан хэрэгсэл, зарим удаан эдэлгээт эд хогшлын мэдээлэлд үндэслэн өрхийг аж байдлын түвшнээр ангилдаг. Хотын байршилд аймгийн төв, Улаанбаатар хотод оршин сууж буй өрх, хөдөөгийн байршилд сумын төв, хөдөөгийн багт оршин сууж байгаа өрхийг хамруулна.

3. Олон шатлалт задаргааны үе шат

1-р түвшний задаргаа

НҮТС-2018 судалгаанаас үндсэн боломжийг илэрхийлэх сонгосон 5 үзүүлэлтийг 15-49 насны эмэгтэйчүүдийн тооцоолов.

2-р түвшний задаргаа

Эмэгтэйчүүдийн хувьд тооцсон үр дүнг аж байдал, байршил, бүс, шашин, үндэстний бүлгүүдээр задалсан.

3-р түвшний задаргаа

15-49 насны эмэгтэйчүүдийн хувьд тооцсон үр дүнг аж байдал-байршил, бүс-байршлын дэд задаргаануудыг гүйцэтгэв.

4-р түвшний задаргаа

НҮТС-аг ашиглан 15-49 насны эмэгтэйчүүдийг - амьдарч буй бүсээр – байршлаас – аж байдлаар задлан ангилж, хамгийн хүнд гачигдлын хэлбэрт амьдарч буй эмэгтэйчүүдийг илрүүлэхийг зорьсон.

Статистикийн хувьд төлөөлөх чадваргүй байгаа учир НҮТС-2018 судалгаанд хамрагдсан 15-49 насны эмэгтэйчүүдийн хувьд 4-р түвшний задаргааг шашин шүтлэг, угсаатны үзүүлэлтүүдийг ашиглан гүйцэтгэх боломжгүй байна.

ТХЗ-ын зарим үзүүлэлтүүдийн олон шатлалт задаргаа

1. Эрт гэрлэлт – ТХЗ 5.3.1

“Насанд хүрээгүй байхдаа гэрлэх” буюу “эрт гэрлэлт” гэдэгт албан болон албан бус хэлбэрээр гэрлэж байгаа талуудын аль нэг нь, эсвэл хоёулаа 18 нас хүрээгүй байхыг ойлгоно.

Дэлхий дахинд жил тутам 12 сая охид 18 нас хүрэхээсээ өмнө гэрлэж байна. Энэ нь минут тутамд 23 охид буюу 3 секунд тутамд 1 охин 18 насанд хүрэхээсээ өмнө гэрлэж байна гэсэн үг юм².


Насанд хүрээгүй байхдаа гэрлэх нь охидын хувь хүний хөгжил болон эрүүл мэндийг эрсдэлд оруулж, жендерийн тэгш бус байдлын үндсэн суурь болж, охид эмэгтэйчүүд ямар нэгэн байдлаар эрэгтэйчүүд, хөвгүүдээс доогуур гэсэн үзлийг бий болгодог.

1-р түвшний задаргаа

НҮТС-2018 судалгаанаас тооцож үзвэл, 15-49 насны эмэгтэйчүүдийн 9.4 хувь нь насанд хүрээгүй байхдаа гэрлэсэн байна. Энэ нь нөхөн үржихүйн насны 10 эмэгтэй тутмын нэг нь 18 нас хүрэхээсээ өмнө гэрлэсэн гэсэн үг юм.

2-р түвшний задаргаа

Зураг 2. Насанд хүрээгүй байхдаа гэрлэсэн 15-49 насны эмэгтэйчүүд, хувиар




Эрт гэрлэх явдал нь чинээлэг өрхийн эмэгтэйчүүдэд ч мөн тохиолдож байна. Өрхийн аж байдлын түшингээр хамгийн чинээлэг бүлгийн 15-49 насны эмэгтэйчүүдийн 5 орчим хувь нь насанд хүрээгүй байхдаа гэрлэсэн бол аж байдлын бусад хэлбэрүүдэд эрт гэрлэх явдал нийтлэг тохиолдож байна.

Муслимийн шашинтай өрхөд эрт гэрлэх явдал дундаж түвшнээс 3.7 дахин бага тохиолдож байгаа бол Буддын шашинтай өрхийн эмэгтэйчүүдийн 8.5 хувь, шашин шүтдэггүй өрхийн эмэгтэйчүүдийн 10.0 хувь нь насанд хүрээгүй байхдаа гэрлэсэн нь байна. Харин шашин шүтлэгийн бусад хэлбэрүүдэд эрт гэрлэх явдал хамгийн өндөр байгаа ч нийт эмэгтэйчүүдийн дунд эзлэх хувийн жин харьцангуй бага хэмжээтэй байна.

² <https://www.girlsnotbrides.org/about-child-marriage/>

3-р түвшний задаргаа

Зураг 3. Насанд хүрээгүй байхдаа гэрлэсэн 15-49 насны эмэгтэйчүүд, бүс-байршил, аж байдлын түвшин-байршил, хувиар



Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийг амьдарч буй бүс, байршлаар задалж харвал эрт гэрлэх явдал төвийн бүсийн - сумын төв, хөдөөгийн багт амьдардаг эмэгтэйчүүдийн хувьд хамгийн өндөр, 13.5 хувьтай, баруун бүсийн – аймгийн төвд амьдардаг эмэгтэйчүүдийн хувьд хамгийн бага, 2.7 хувь байна.

Аж байдлын түвшин, байршлаар задалж харвал, аж байдлын дундаас дээгүүр, дээгүүр түвшин бүхий - хотод амьдардаг 15-49 насны эмэгтэйчүүдийн эрт гэрлэх явдал хөдөөд амьдардаг эмэгтэйчүүдтэй харьцуулахад харьцангуй өндөр байгаа бол аж байдлын түвшин доошлох тусам эрт гэрлэлт нь хот, хөдөөд зөрүүгүй болж байна.

Насанд хүрээгүй байхдаа гэрлэх явдал өрхийн аж байдлын түвшин дээгүүр үед ч өндөр хэвээр хадгалагдсаар байгаа нь жендерийн тэгш бус байдлын үндэс суурь манай орны нийгмийн бүхий л давхаргыг хамран оршин байсаар байгааг илтгэж байгаа юм.


4-р түвшний задаргаа

“Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа 2018”-аас насанд хүрээгүй байхдаа гэрлэсэн, 15-49 насны эмэгтэйчүүдийг, оршин суугаа бүс, байршил, өрхийн аж байдлын түвшнээр нэгэн зэрэг задлан авч үзэхэд, хамгийн гачигдалтай, эмзэг бүлэг нь төвийн бүсийн, хөдөөгийн, аж байдлын доогуур түвшний өрхөд амьдардаг эмэгтэйчүүд байна. Эдгээр эмэгтэйчүүдийн 18.5 хувь буюу ойролцоогоор 5 эмэгтэй тутмын нэг нь албан болон албан бус хэлбэрээр насанд хүрээгүй байхдаа гэрлэсэн байна. Энэ нь дундаж түвшнээс даруй 2 дахин өндөр байгаа юм.

Баруун бүсийн, аймгийн төвд амьдардаг дундаас дээгүүр аж байдлын түвшинтэй өрхөд амьдарч байгаа эмэгтэйчүүдийн дунд эрт гэрлэх явдал хамгийн бага, 0.4 хувьтай байна. Мөн Баруун бүсэд аж байдал болон байршил харгалзахгүйгээр эрт гэрлэх тохиолдол маш бага байна. Энэ нь шашин шүтлэгээс хамаарсан байх магадлалтай.

Эмэгтэйчүүд эрт гэрлэх явдал нь аж байдлын түвшнээс хамаарахгүй байна.

Зураг 4. Насанд хүрээгүй байхдаа гэрлэсэн 15-49 насны эмэгтэйчүүд, аж байдлын түвшин, байршил, бүсээр, хувиар³



³ Статистикийн хувьд төлөөлөх чадваргүй бүлгүүдийг хассан.

2. Ундны усны хангамж – ТХЗ 6.1.1

Хангалттай хэмжээний, чанартай, цэвэр устай байх нь эрүүл мэндээ хамгаалах, сайн-сайхан байдлын үндэс болдог. Баталгаат ундны усны эх үүсвэрээр хангагдсан эсэхийг ТХЗ-д ундны усны “суурь” үйлчилгээг хэрэглэж байгаа хүн амын нийт хүн амд эзлэх хувь хэмжээгээр тооцно.

Хүснэгт 2. Ундны усны үйлчилгээний түвшин

Үйлчилгээний түвшин	Тодорхойлолт
Баталгаат	Ус дамжуулах төвлөрсөн системд холбогдсон, хүссэн үедээ хангалттай хэмжээгээр хэрэглэх боломжтой, ус нь ямар нэгэн бохирдол, химийн хольцгүй сайжруулсан эх үүсвэр бүхий ундны ус.
Суурь	Ундны ус авах хугацаа нь (ирж, очих 2 талдаа) 30 хүртэлх минут (хүлээх хугацааг оруулна) бүхий сайжруулсан эх үүсвэр.
Хязгаарлагдмал	Ундны ус авах хугацаа нь (ирж, очих 2 талдаа) 30-аас дээш минут (хүлээх хугацааг оруулна) бүхий сайжруулсан эх үүсвэр.
Сайжруулаагүй	Хамгаалагдаагүй эх үүсвэрээс ундны усаа авах.
Гадаргын ус	Гол, далан, нуур, цөөрөм, суваг гэх мэт гадаргын уснаас ундны усаа авах.

Ундны усны сайжруулсан эх үүсвэрт төвлөрсөн эсвэл гүний усны ус дамжуулах системт, хамгаалагдсан худаг (гүний худаг, гар худаг), тохижуулж хамгаалсан булаг шанд, борооны ус цуглуулагч, мөн түүнчлэн савласан болон зөөврийн ус зэрэг багтана.

Ундны усны суурь хэрэглээгээр хангагдах гэдэг нь сайжруулсан эх үүсвэр бүхий, ундны ус авахдаа зарцуулж буй хугацаа нь 30 хүртэлх минут байхыг ойлгоно. (United Nations, 2018)

Зураг 5. Дэлхийн ундны усны хангамж, хувиар, 2015 он



НҮБ-ын тайланд дурдсанаар⁴ ундны усны суурь үйлчилгээний хүртээмж, дэлхийн түвшинд, 2017 оны байдлаар 88 хувьтай байсан бол Монгол Улсын хэмжээнд 2018 оны байдлаар 82.5⁵ хувь, дэлхийн дунджаас 5.5 пунктээр доогуур байна.

1-р түвшний задаргаа

НҮТС-2018 судалгааны үр дүнгээс тооцож үзвэл, 15-49 насны эмэгтэйчүүдийн 83.2 хувь нь ундны усны суурь үйлчилгээгээр хангагдсан, 16.8 хувь нь суурь үйлчилгээгээр хангагдаагүй байна. Ундны усны суурь үйлчилгээг i)сайжруулсан эх үүсвэр бүхий, ii)усанд явж ирэх хугацаа нь 30 минутаас бага байх гэсэн олон улсын тодорхойлолтын дагуу задлан ангилбал, i)ундны усны сайжруулсан эх үүсвэрээр хангагдаж чадахгүй байгаа 15-49 насны эмэгтэйчүүд, жигнэсэн дунджаар 12.8 хувьтай, ii)ус аваад буцаж ирэхдээ 30-аас дээш минут зарцуулж буй эмэгтэйчүүд, жигнэсэн дунджаар 8.6 хувьтай байна.

Ундны усны суурь үйлчилгээгээр хангагдаж чадахгүй байх явдал нь сайжруулсан эх үүсвэр бүхий байгууламж хүртээмжгүй байгаагаас голчлон шалтгаалж байна.

Эх үүсвэр: WHO, UNICEF (2017)


⁴ Synthesis Report on Water and Sanitation, 2018

⁵ НҮТС-2018

2-р түвшний задаргаа

Аж байдлын хамгийн доогуур түвшний өрхийн эмэгтэйчүүд ундны усны суурь үйлчилгээгээр хангагдаж чадахгүй байх явдал бусад бүлгүүдээс харьцангуй өндөр, дундаас доогуур бүлэгтэй харьцуулахад 4.4 дахин их байна.

Зураг 6. Ундны усны суурь үйлчилгээгээр хангагдаагүй 15-49 насны эмэгтэйчүүд, хувиар




Сумын төв, хөдөөгийн багт амьдарч байгаа нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн ундны усны суурь үйлчилгээгээр хангагдаж чадахгүй байх нь Нийслэл, аймгийн төвд амьдарч байгаа эмэгтэйчүүдтэй харьцуулахад 8.1 дахин өндөр байна.

Муслим шашинтай, 15-49 насны 3 эмэгтэй тутмын нэг нь уг суурь үйлчилгээг хүртэж чадахгүй байгаа бол угсаатны цөөнх өрх гэрийн эмэгтэйчүүдийн ундны усаар хангагдаагүй байх явдал нь дундаж түвшнээс өндөр байгаа юм.

3-р түвшний задаргаа

15-49 насны эмэгтэйчүүдийн ундны усны хангамжид хот хөдөөгийн байршлын нөлөөлөл өндөр байна.

Зураг 7. Ундны усны суурь хэрэглээгээр хангагдаагүй 15-49 насны эмэгтэйчүүд, аж байдлын түвшнээр, байршлаар, хувиар




Байршил, бүсээр ангилан авч үзвэл хангайн болон баруун бүсийн сумын төв, хөдөөгийн багт амьдарч байгаа 15-49 насны эмэгтэйчүүдийн тал хувь нь ундны усны суурь үйлчилгээгээр хангагдаагүй байна. Улаанбаатар хотын хувьд энэ үзүүлэлт дундаж түвшнээс 3.3 дахин доогуур байгаа хэдий ч хүн амын нягтрал ихтэйгээс шалтгаалан хамралтын хүрээ өндөр байх магадлалтай.

Өрхийн аж байдлын түвшин, байршлаар авч үзэхэд сумын төв, хөдөөгийн багийн аж байдлын хамгийн доогуур түвшний эмэгтэйчүүдийн 63.5 хувь нь ундны усны суурь үйлчилгээгээр хангагдаагүй, харин бусад бүлгүүдийн хувьд дунджаас доогуур түвшинд байна.

4-р түвшний задаргаа

Зураг 8. Ундны усны суурь хэрэглээгээр хангагдаагүй 15-49 насны эмэгтэйчүүд, аж байдлын түвшин, бүс, байршлаар, хувиар



Ундны усны суурь үйлчилгээгээр хангагдаагүй хамгийн гачигдалтай, эмзэг бүлэг нь баруун бүсийн, хөдөөгийн, аж байдлын доогуур түвшний өрхөд амьдардаг эмэгтэйчүүд байна.

Эдгээр эмэгтэйчүүдийн 70.3 хувь нь өдөр тутамдаа ундны усны суурь үйлчилгээг ашиглаж чадахгүй байна.

Ундны усны суурь хэрэглээгээр хангагдаагүй байх нь доогуур аж байдлын түвшний өрхөд амьдардаг эмэгтэйчүүдийн хувь оршин сууж буй бүс, байршил харгалзахгүйгээр бусад аж байдлын түвшний бүлгүүдтэй харьцуулахад харьцангуй өндөр байгаа юм.

3. Ариун цэврийн байгууламжгүй – ТХЗ 6.2.1


ТХЗ 6.2.1-а дэх үзүүлэлт эрүүл ахуйн шаардлага хангасан ариун цэврийн байгууламжаар хангагдсан хүн амын хувийг ариун цэврийн байгууламжийн суурь үйлчилгээний хэрэглээгээр тооцдог.

Хүснэгт 3. Ариун цэврийн байгууламжийн үйлчилгээний түвшин⁶

Үйлчилгээний түвшин	Тодорхойлолт
Баталгаат	Бусад өрхтэй хамтран ашигладаггүй, бохир нь шууд зайлуулагдаж, тусгаарлагддаг сайжруулсан байгууламж.
Суурь	Бусад өрхтэй хамтран ашигладаггүй сайжруулсан байгууламж.
Хязгаарлагдмал	2 болон түүнээс олон өрхүүдтэй хамтран ашигладаг сайжруулсан байгууламж
Сайжруулаагүй	Хөл гишгэх тавиургүй нүхэн жорлон, өлгөдөг эсвэл саванд хийдэг бие засах газар
Задгай тунгаагуур	Хүний ялгадсыг хөрсөнд, ойд, усанд, далайн эрэг дээр гэх мэт задгай газарт хаях

Ариун цэврийн сайжруулсан байгууламж гэдэг нь хүний ялгадсыг зохистой байдлаар, хүнд хүргэхгүйгээр зайлуулж тусгаарлах нөхцөлийг бүрдүүлэх юм.

Зураг 9. Ариун цэврийн байгууламжийн хангамж, Дэлхийн түвшинд, 2015 он, хувиар



Олон улсад бохир ус зайлуулах хоолойд холбогдсон даралтат болон зөөж хийх ус татуургатай, битүү тунгаагуур болон модон жорлон, агааржуулагч бүхий сайжруулсан модон жорлон, энгийн нүхэн жорлон, мөн ялгадсыг салгаж бордоо болгох зориулалт бүхий жорлонг сайжруулсан ариун цэврийн байгууламжид хамруулж авч үздэг.

Харин манай улсын хувьд гэр хорооллын дийлэнх энгийн нүхэн жорлон нь хөрсний бохирдлоос сэргийлэх доторлогоогүй байдаг бөгөөд эрүүл ахуйн шаардлага хангаж байна гэж үзэхэд учир дутагдалтай байдаг.

НҮБ-ын тайланд дурдсанаар ариун цэврийн байгууламжийн суурь үйлчилгээний хэрэглээ, дэлхийн түвшинд, 2017 оны байдлаар 68 хувьтай байсан бол манай Монгол улсын хэмжээнд 2018 оны байдлаар 88.8⁷ хувьтай байна.

Эх үүсвэр: WHO, UNICEF (2017)

⁶ WHO, UNICEF

⁷ НҮТС-2018


1-р түвшний задаргаа

НҮТС-2018 судалгааны үр дүнгээс тооцож үзвэл, 15-49 насны эмэгтэйчүүдийн 74.85 хувь нь ариун цэврийн суурь үйлчилгээ буюу бусад өрхтэй хамтран ашигладаггүй, сайжруулсан ариун цэврийн байгууламжаар хангагдсан байна. Харин 15-49 насны эмэгтэйчүүдийн 25.15 хувь нь ариун цэврийн суурь үйлчилгээгээр хангагдаагүй. Энэ нь нөхөн үржихүйн насны дөрвөн эмэгтэй тутмын нэг нь ариун цэврийн суурь үйлчилгээг хүртэж чадахгүй байна гэсэн үг юм.

2-р түвшний задаргаа

Аж байдлын хувьд авч үзвэл хамгийн ядуу бүлгийн нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн тал хувь нь, хөдөө амьдарч буй эмэгтэйчүүдийн 36 хувь нь ариун цэврийн байгууламжийн суурь үйлчилгээг ашиглаж чадахгүй байна.

Зураг 10. Ариун цэврийн байгууламжийн суурь үйлчилгээгээр хангагдаагүй 15-49 насны эмэгтэйчүүд, хувиар



Манай орны Баруун бүсийн Баян-Өлгий аймагт Казах ястан аймгийн хүн амын дийлэнх хэсгийг бүрдүүлдэг, Ховд аймагт Урианхай, Захчин, Торгууд, Мянгад ястны цөөнх, Увс аймагт Дөрвөд, Баяд ястан амьдардаг онцлогтой⁸.

Угсаатны цөөнхийн нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн 30 хувь нь ариун цэврийн байгууламжийн суурь үйлчилгээгээр хангагдаж чадахгүй байна. Энэхүү ялгаа нь бүсийн болон шашин шүтлэгийн үзүүлэлтүүдэд мөн хадгалагдаж байна.


3-р түвшний задаргаа

Хангай, төв, зүүн бүсийн хөдөөгийн эмэгтэйчүүд сайжруулсан ариун цэврийн байгууламж ашиглаж чадахгүй байх нь тухайн бүс тус бүрийн аймгийн төвд амьдардаг эмэгтэйчүүдтэй харьцуулахад дунджаар 1.9 дахин өндөр байна. Харин баруун бүсийн хувьд хот хөдөөгийн ялгаа төдийлөн ажиглагдаагүй.

Дундаж амьдралтай, Улаанбаатар хот, аймгийн төвд амьдардаг эмэгтэйчүүдийн 37.2 хувь нь бусад өрхтэй хамтран ашигладаггүй, сайжруулсан ариун цэврийн байгууламжаар хангагдаагүй, өөрөөр хэлбэл нийгмийн үндсэн чухал суурь үйлчилгээг хүртэж чадахгүй байна.


⁸ <https://www.adb.org/sites/default/files/project-documents/49430/49430-005-ippf-mn.pdf>

Зураг 11. Ариун цэврийн байгууламжийн суурь үйлчилгээгээр хангагдаагүй 15-49 насны эмэгтэйчүүд, аж байдлын түвшнээр, байршлаар, хувиар



4-р түвшний задаргаа

Зураг 12. Ариун цэврийн байгууламжийн суурь үйлчилгээгээр хангагдаагүй 15-49 насны эмэгтэйчүүд, бүсээр, байршлаар, аж байдлын түвшнээр, хувиар



Баруун бүсийн, аймгийн төвд амьдарч байгаа, аж байдлын доогуур түвшний нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн ариун цэврийн байгууламжийн суурь үйлчилгээгээр хангагдаагүй байх тохиолдол хамгийн өндөр, 63.3 хувь байна.

Улаанбаатар хотод дундаж, дунджаас доогуур, доогуур түвшний аж байдалтай нөхөн үржихүйн насны 2 эмэгтэй тутмын нэг нь ариун цэврийн байгууламжийн суурь түвшний үйлчилгээг хүртэж чадахгүй байна.

Ариун цэврийн суурь үйлчилгээгээр хангагдаж чадахгүй байх нь аж байдлын түвшнээс шууд хамааралтай байгаа бөгөөд аж байдлын дундаж түвшний өрхөд амьдардаг эмэгтэйчүүдийн гачигдлын түвшин нь дундаж хэмжээ болох 25.2 хувиас өндөр буюу бараг бүгд энэхүү суурь боломжоор хангагдаагүй байгаа юм.

4. Хоол болгох цэвэр түлшгүй – ТХЗ 7.1.2

Хүний эрүүл мэнд болон хүрээлэн буй орчинд хоёуланд нь нөлөөлдөг учир хоол болгох цэвэр түлшээр хангагдах явдал нь дэлхий нийтийн анхаарлын төвд орсон асуудал болоод байгаа билээ.

Хоол болгох цэвэр түлшээр хангагдсан хүн ам нийт дэлхийн хүн амын 56 хувийг 2010 онд эзэлж байсан бол 2018 онд 63 хувь болсон. Гэсэн ч энэхүү өсөлт нь зарим улс орнуудад хүн амын өсөлтөөс удаан байгаа бөгөөд хоол болгох цэвэр түлшээр хангагдах явдал дэлхий нийтийн хэмжээнд удааширч байгаа юм.

Мод, нүүрс зэрэг хатуу түлшийг ашигласнаар үүсэх гэр доторх агаарын бохирдлоос үүдэн жил бүр 2.8 сая хүн нас барж байгаагийн ихэнх нь эмэгтэйчүүд, хүүхдүүд байна⁹.

Хатуу түлш, мод, нүүрс зэрэг нь шатах явцдаа хорт бодис ялгаруулан дотоод орчны агаарын бохирдол, утаа үүсгэж, энэ нь астма, чих амьсгалын замын халдвар, сүрьеэ, хамар хоолойн хавдар, хүзүүний хавдар, дутуу жинтэй төрөх, хугацаанаас эрт төрөх зэрэг эрүүл мэндийн эрсдэлүүдийг бий болгодог.

Өдөр тутамдаа хоол бэлтгэх, болгох үйл ажиллагааг ихэвчлэн эмэгтэйчүүд гүйцэтгэдэг учраас цэвэр бус түлш ашигласнаас үүсэх хор уршиг нь эмэгтэйчүүд, мөн хүүхдүүдэд илүү нөлөөлдөг байна.

Одоогийн өсөлтийн түвшнээр тооцож үзвэл, 2030 он гэхэд 2.3 тэрбум хүн хоол болгох цэвэр түлшээр хангагдаагүй хэвээр байх ба энэ нь дэлхийн хүн амын бараг гуравны нэг хэсэгтэй тэнцэж, тэдгээрийн ихэнх нь эмэгтэйчүүд, хүүхдүүд байх юм¹⁰.


Цэвэр түлшинд цахилгаан эрчим хүч, шингэрүүлсэн хийн түлшийг тооцдог бол цэвэр бус түлшинд бүх төрлийн хатуу түлш хамаарагддаг (World Health Organization, 2014).

1-р түвшний задаргаа

НҮТС-2018 тайланд хоол хийхдээ голчлон хэрэглэдэг цэвэр түлш технологийн хэрэглээ Монгол Улсын хэмжээнд 50.0 хувьтай тооцогдсон. Үүнийг эмэгтэйчүүдээр ангилан авч үзвэл, 15-49 насны эмэгтэйчүүдийн 52.8 хувь нь хоол хийхдээ цэвэр түлш ашигладаг, 47.2 хувь нь цэвэр түлшээр хангагдаагүй байна.

2-р түвшний задаргаа

Зураг 13. Хоол болгох цэвэр түлш ашигладаггүй 15-49 насны эмэгтэйчүүд, хувиар



Өрхийн аж байдлын түвшнээр авч үзвэл чинээлэг өрхийн эмэгтэйчүүд өдөр тутмын хоол бэлтгэх, болгох үйл ажиллагаандаа 100 хувь цэвэр түлш буюу цахилгаан, шингэрүүлсэн хий ашигладаг бол аж байдлын доогуур түвшний өрхөд амьдардаг бүх эмэгтэйчүүд цэвэр бус, хатуу түлш ашиглаж байна.


Баруун бүс дэх 10 эмэгтэй тутмын 9 нь хоол болгох цэвэр түлшээр хангагдаагүй байгаа нь бусад бүсүүдтэй харьцуулахад хамгийн өндөр байна. Муслимийн шашинтай өрхөд амьдардаг эмэгтэйчүүд хоол болгох явцдаа цэвэр түлш ашиглахгүй байх нь шашин шүтлэгийн бусад хэлбэрүүдтэй харьцуулахад ойролцоогоор 2 дахин өндөр байгаа юм.

⁹Accelerating SDG 7 achievement, <https://sustainabledevelopment.un.org/content/documents/17489PB12.pdf>

¹⁰ <https://unstats.un.org/sdgs/report/2020/goal-07/>

3-р түвшний задаргаа


Зураг 14. Хоол болгох цэвэр түлш ашигладаггүй 15-49 насны эмэгтэйчүүд, аж байдлын түвшнээр, байршлаар, хувиар



Хоол болгох цэвэр түлшээр хангагдахгүй байх нь аж байдлын түвшинтэй шууд хамааралтай, хаана амьдарч байгаагаас шалтгаалахгүйгээр чинээлэг өрхийн эмэгтэйчүүд бүгд цэвэр эрчим хүчний эх үүсвэрээр хангагдсан байна.

4-р түвшний задаргаа

Зураг 15. Хоол болгох цэвэр түлш ашигладаггүй 15-49 насны эмэгтэйчүүд, бүсээр, байршлаар, аж байдлын түвшнээр, хувиар



Аж байдлын дундаас дээгүүр түвшний өрхүүд ихэвчлэн цэвэр түлш ашиглаж байгаа бол, дундаж болон түүнээс доогуур түвшний өрхүүд хоол болгохдоо цэвэр бус түлш ашиглаж байна.

Өдөр тутмын хоол хийх явцдаа цэвэр түлшээр хангагдаагүй байх нь охид, эмэгтэйчүүдийг чадавхжуулахад томоохон түлхэц болдог. Учир нь охид, эмэгтэйчүүдийн өдөр тутмын, үнэлэгддэггүй гэрийн ажил болох хоол хийх, ус авах, түлш бэлтгэх гэх мэтэд зарцуулах хугацаа их байдгаас боловсрол олж авах, цалин хөлстэй хөдөлмөр эрхлэхэд зарцуулах хугацаа нь багасдаг. Ингэснээр жендерийн тэгш бус байдлыг нэмэгдүүлж, ядуурлын үндсэн шалтгаан болоод зогсохгүй, хүрээлэн буй орчныг доройтуулан, агаарын бохирдлыг үүсгэдэг.

5. Орон сууцны тохиромжгүй нөхцөл - ТХЗ 11.1.1

2007 оноос хойш дэлхийн нийт хүн амын хагасаас илүү хувь нь хот суурин газарт амьдарч, 2030 он гэхэд 60 хувь хүрэх тооцоотой байна. Дэлхийн энэхүү хурдацтай хотжилт тэгш бус байдлыг улам нэмэгдүүлж, ядуучуудын хороололд амьдарч байгаа хүмүүсийн тоо тасралтгүй өссөөр байна.

Дэлхийн олон хотуудад ядуучуудын маш том дүүрэг бий болж, хотын захын хорооллын хүрээгээ тэлсээр байгаа юм. Ийм ч учраас хотжилтын хамгийн том асуудал нь амьдрахад тохиромжтой орон байраар хүмүүсийг хангах явдал болоод байна.

Амьдрахад тохь тухтай, тохиромжтой орон байртай байна гэдэг нь эрүүл мэндээ хамгаалах, хүмүүн капиталаа нэмэгдүүлэх, хөгжлөөс илүү их хүртэх боломжийг олгодог¹¹.

Дэлхий нийтээр 1.6 тэрбум хүн орон сууцны тохиромжгүй нөхцөлд амьдарч, үүнээс 1 тэрбум хүн ядуучуудын хороолол, урц овохойд амьдарч байна¹².

Орон сууцны тохиромжтой нөхцөлийг үнэлэх 5 бүрэлдэхүүн хэсэг байх бөгөөд үүний нэг нь амьдрах хүрэлцээтэй зай, талбайтай байх юм.


Нэг өрөөнд амьдардаг хүний тоо 3-аас их бол амьдрах хангалттай орон зайгүй, хэт их бөөгнөрсөн гэж үзнэ.

1-р түвшний задаргаа

15-49 насны эмэгтэйчүүдийн 66.1 хувь нь хангалттай зай талбайд амьдарч байгаа бол 33.9 хувь нь хангалттай зай талбайд амьдарч чадахгүй байна. Хангалттай зай талбайгүй, хэт их бөөгнөрөн амьдрах нь хоорондын зай барих боломжгүй, хувийн орон зайгүй болгодог.

2-р түвшний задаргаа

Зураг 16. Хангалттай зай талбайд амьдардаггүй 15-49 насны эмэгтэйчүүд, хувиар



¹¹ SDG, Metadata, Зорилт 11

¹² UN-Habitat (2016). World Cities Report. UN-Habitat (2005). Financing Shelter.

Аж байдлын дундаас доогуур түвшний өрхөд амьдардаг 15-49 насны эмэгтэйчүүдийн 59.8 хувь нь хангалттай зай талбайд амьдарч чадахгүй байгаа нь бусад аж байдлын түвшний эмэгтэйчүүдээс хамгийн өндөр үзүүлэлттэй байна.


Өмнөх үр дүнгүүдээс ялгаатай нь, зүүн болон хангайн бүсэд хүн амын бөөгнөрлийн уг үзүүлэлт бусад бүсүүдээс өндөр байна.

Судалгаа явагдсан 2018 онд зүүн бүсэд нийт хүн амын 6.8 хувь, хангайн бүсэд 18.7 хувь оршин сууж байв. Энэ нь хангалттай зай талбайд амьдарч чадахгүй байх нь тухайн бүсэд хүн ам хир их төвлөрснөөс хамаарахгүй байгааг илтгэж байгаа юм.

Шашны бүлгийн цөөнх, угсаатны цөөнх байх нь хангалттай зай талбайд амьдарч чадахгүй байх гачигдлын түвшнийг нэмэгдүүлж байна.

3-р түвшний задаргаа

Зураг 17. Хангалттай зай талбайд амьдардаггүй 15-49 насны эмэгтэйчүүд, аж байдлын түвшнээр, байршлаар, хувиар



Бүсээр, байршлаар авч үзвэл зүүн бүсийн, хөдөө амьдардаг нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүд хангалттай зай талбай бүхий орчинд амьдарч чадахгүй байгаа нь бусад бүсүүдтэй харьцуулахад хамгийн өндөр, аж байдлын түвшнээр авч үзвэл хотод амьдардаг нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүд хангалттай зай талбай бүхий орчинд амьдарч чадахгүй байх нь хөдөө амьдардаг эмэгтэйчүүдтэй харьцуулахад өндөр байна.


Аймгийн төв, Нийслэл хотод оршин суудаг, аж байдлын доогуур түвшний өрхийн, 15-49 насны эмэгтэйчүүдийн 86.1 хувь нь өөрийн гэсэн хувийн орон зайгүй, олуулаа бөөгнөрөн амьдарч байна.

4-р түвшний задаргаа

Аж байдлын доогуур түвшний өрхийн 15-49 насны эмэгтэйчүүдээс Улаанбаатар хотод болон Хангайн бүсийн-аймгийн төвд амьдардаг бүх эмэгтэйчүүдэд өөрсдийн гэсэн хувийн орон зай байхгүй байна.

Дээгүүр аж байдлын түвшинтэй, Улаанбаатар хотын 15-49 насны эмэгтэйчүүдийн 17.9 хувь нь хангалттай зай талбай бүхий орчинд амьдарч чадахгүй байгаа бол бусад бүсүүдийн хувьд “0” хувьтай байна.

Зураг 18. Амьдрах хангалттай зай талбайгүй 15-49 насны эмэгтэйчүүд, бүсээр, байршлаар, аж байдлын түвшнээр, хувиар



Нэгдсэн үр дүн


Эмэгтэйчүүд, охидод тулгардаг тэгш бус байдал нь анх төрөхөөс нь эхлэн бүхий л амьдралынх нь туршид үргэлжилж байдаг.

Эмэгтэйчүүдийн өдөр тутмын, үнэлэгддэггүй, гар ажиллагаатай ажлуудыг хөнгөвчилснөөр тэдний эрүүл мэнд, сайн сайхан байдлыг дэмжиж, чөлөө зав гаргадаг бөгөөд ингэснээр эдийн засгийн хувьд чадавхжих боломжийг олгодог.

Эмэгтэйчүүдийг чадавхжуулж, өөрийн гэсэн орлоготой болгосноор тэднээс хамааралтай байдаг хүүхдүүд, өндөр настнуудад илүү дээр аж байдалд амьдрал нөхцөлийг бүрдүүлдэг. Тиймээс эмэгтэйчүүдийн тэгш бус боломжийн асуудал нь зөвхөн тэдэнд хамааралтай асуудал биш бөгөөд үр дүн нь нийт нийгмийн сайн сайхан байдалд нөлөөлдөг.

Үндсэн боломжийг илэрхийлэх үзүүлэлтүүдээс 5 үзүүлэлтийг сонгон авч НҮТС-2018 судалгаанаас тооцоолоход, 15-49 насны эмэгтэйчүүдийн 16.8 хувь нь үндны усны суурь хэрэглээгээр хангагдаагүй, 25.2 хувь нь ариун цэврийн суурь үйлчилгээг ашиглаж чадахгүй, 47.2 хувь нь хоол болгох цэвэр түлшгүй, 34.0 хувь нь амьдрахад тохиромжтой зай талбайтай орон гэргүй, 9.4 хувь нь 18 наснаас өмнө гэрлэсэн байна.

Зураг 19. Ялгаатай бүлгүүдэд амьдарч буй 15-49 насны эмэгтэйчүүдийн тэгш бус байдлын үзүүлэлтүүд, хувиар



“Хөгжлөөс хэнийг ч орхигдуулахгүй” урианы дор хийсэн шинжилгээгээр, Хангайн бүсийн - аймгийн төвд амьдардаг - аж байдлын доогуур түвшний өрхийн - 15-49 насны эмэгтэйчүүд сонгож авсан үзүүлэлтүүдийн дагуух давхар гачигдалд хамгийн ихээр өртсөн байна.

Эдгээр эмэгтэйчүүдийн 57.8 хувь нь үндны усны суурь хэрэглээгээр хангагдаагүй, 34.7 хувь нь ариун цэврийн суурь үйлчилгээг ашиглаж чадахгүй, 100 хувь буюу бүгд хоол болгох цэвэр түлш болон амьдрахад тохиромжтой зай талбайтай орон гэргүй, 17.6 хувь нь насанд хүрээгүй байхдаа гэрлэсэн байна.

Хамгийн эмзэг байдалд амьдарч буй эдгээр эмэгтэйчүүд дундаж түвшнээс 2.3 дахин доогуур үзүүлэлттэй байна.

Тооцооллын дагуух 5 үзүүлэлтээр хамгийн сайн үнэлгээтэй бүлэг нь Зүүн бүсийн – аймгийн төвийн-дээгүүр аж байдлын түвшин бүхий өрхөд амьдардаг эмэгтэйчүүд байна. Эдгээр эмэгтэйчүүд бүгд хоол болгохдоо цэвэр түлш ашигладаг, ариун цэврийн суурь байгууламжтай, ундны усны суурь үйлчилгээнд хамрагдсан байгаа боловч 21.0 хувь нь хангалттай зай талбайд амьдарч чадахгүй, 2.4 хувь нь эрт гэрлэсэн байна.

Баруун бүсийн доогуур аж байдлын түвшин бүхий эмэгтэйчүүдийн хувьд эрт гэрлэлтээс бусад үзүүлэлт байршлаас үл шалтгаалан маш муу байгаа хэдий ч түүврийн хангалттай бус хэмжээнээс шалтгаалан бусад бүлгүүдтэй харьцуулах боломжгүй, төлөөлөх чадваргүй байна.

Ариун цэврийн байгууламж, хоол болгох цэвэр түлш, ундны усны хэрэглээ нь аж байдлын түвшнээс голчлон шалтгаалж байгаа бол хангалттай зай талбайд амьдарч чадахгүй байх нь нийт эмэгтэйчүүдийн дунд нийтлэг бөгөөд аж байдлын түвшин, байршил, шашин шүтлэг зэргээс хамаарахгүй байгаа юм. Харин эрт гэрлэлт нь шашин шүтлэгээс хамаардаг байх магадлалтай байна.

Боломжийг олж авах тэгш бус байдлын үзэл баримтлалаар авч үзвэл, ариун цэврийн байгууламжийн суурь үйлчилгээгээр хангагдаагүй, хоол болгохдоо хатуу түлш ашигладаг, ундны усны суурь хэрэглээгээр хангагдаж чадахгүй байх нь охид эмэгтэйчүүдийн хөгжлөөс хүртэх боломжийг хязгаарлаж, өрхийн аж байдлын түвшнийг доройтуулж байна. Өөрөөр хэлбэл инженерийн шугам сүлжээ, цахилгаан, дулаанаар хангагдах боломжгүй байх нь охид эмэгтэйчүүдийг давхардсан гачигдалд амьдруулж, хөгжлөөс хоцроон, ядуурлаас ангижрах боломжгүй болгож байна.

Хэрэв охид, эмэгтэйчүүд хөдөөгийн, ядуу өрхөд амьдардаг бол хөгжлийн үр дүнг хүртэх боломжгүй, ард үлдэж хоцрогдох, давхардсан гачигдлын эрсдэлд амьдарч байх магадлал хамгийн өндөр байна.

Энэхүү шинжилгээгээр тооцсон бүс - байршил - аж байдлын бүлгүүдийн задаргаа нь НҮТС-2018 судалгааны үр дүнгээс эмэгтэйчүүдийн хувьд тооцогдох хамгийн боломжит олон шатлалт задаргаа болж байна. Боловсролын түвшин, угсаатны цөөнх, шашин шүтлэг гэх мэт нарийвчилсан задаргааг хийх, бүлгүүдийн онцлогийг олж илрүүлэхэд түүврийн хэмжээ маш хангалтгүй байна.

Жендерийн тэгш байдал нь тогтвортой хөгжлийн үйл явцын үндсэн тулгуур болдог. Ийм ч утгаар үр дүнтэй бодлого төлөвлөлт, олон улсын конвенцын хэрэгжилтэд жендерийн статистикийг ашиглагдах хэрэгцээ үлам бүр нэмэгдсээр байна.

Улс орнуудын үндэсний статистикийн байгууллагууд жендерийн асуудлуудад чиглэсэн программ хэрэгжүүлэн, албан ёсны статистик дахь жендерийн статистикийн мэдээллийг нэмэгдүүлж байна.

Жендерийн статистик мэдээллийг нэмэгдүүлэх, боломжит үзүүлэлтүүдээр ангилан задалж харуулах нь охид эмэгтэйчүүдэд өдөр тутам тулгараад буй шударга бус байдлыг залруулах үндэслэл болно.

Иймд олон шатлалт задаргааны ялгаатай бүлгүүд нь төлөөлөх чадвартай, статистикийн хувьд ач холбогдол бүхий байхуйцаар түүвэр судалгааг зохион байгуулах, үүний тулд түүврийн хэмжээг нэмэгдүүлэх хэрэгцээ, шаардлага үүсэж байна.

Ашигласан материал

- United Nations. (2018). Sustainable Development Goal 6. *Synthesis Report 2018 on Water and Sanitation* (хүүд. 37).-Д Geneva: United Nations Publications.
- UN Women. (2018). TURNING PROMISES INTO ACTION. *GENDER EQUALITY IN THE 2030 AGENDA FOR SUSTAINABLE DEVELOPMENT*.-Д AGS Custom Graphics, an RR Donnelly Company.
- United Nations. (2016). Studies in Methods, Series F No. 111. S. D. Department of Economic and Social Affairs-Д, *Integrating a Gender Perspective into Statistics* (хүүд. 218). NY: United Nations publication.
- World Health Organization. (2014). WHO guidelines. *WHO guidelines for indoor air quality: household fuel combustion* (хүүд. 16).-Д Geneva: WHO Document Production Services.
- ҮСХ. (2020). *Тогтвортой хөгжлийн зорилго* (хүүд. 3).-Д Улаанбаатар.